

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МАЛЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГАА, ТҮҮНД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨД НЯГТЛАН БОДОХ
БҮРТГЭЛ БОЛОН УЛСЫН БАЙЦААГЧ НАРААС ТАВИХ ХЯНАЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХӨА-2025/52-ШТА-ГА

Дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар

Утас: 88883317

Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114

Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор

Утас: 92113932

Б.Давааням

Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитор

Утас: 88688168

Г.Ичинхорлоо

Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Аудитор

Утас: 99036832

Б.Ариунтуяа

Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn

Аудитор

Утас: 99387994

Ц.Чагнаадорж

Цахим хаяг: chagnaadorj.ts@audit.gov.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
khuvsgul.audit.mn/state/16 цахим хуудаснаас авна уу.

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
А.Эрдэнэбаатар
Аудитын менежер
Б.Тэгшдэлгэр
Ахлах аудитор
Б.Давааням
Аудитор
Г.Ичинхорлоо
Б.Ариунтуяа
Ц.Чагнаадорж

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл гарвал 70384043
дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум
Аймгийн ЗДТГ-ын “А”
корпус 3 давхар

Цахим хаяг:
audit.mn/?page_id=579

2025 оны 11 дүгээр сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

БҮЛЭГ 1. А. Аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж хэрэгжүүлэн ажилласнаар халдварт өвчний тохиолдол буурсан байна.

А.1 Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан холбогдох журам, стандартаар малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг оновчтой тодорхойлсон байна.

А.2 Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газар нь малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн төлөвлөж хэрэгжүүлэн ажилласнаар халдварт өвчний тохиолдол буурсан байна.

А.3 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг малын тоо, өвчний тархалтад үндэслэн тооцож төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 2. Б. Мал эмнэлгийн газар нь шат шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд зөрчилтэй анхан шатны баримтаар 1,313.6 сая төгрөгийн үйлчилгээний хөлсийг олгосон байна.

Б.1 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажилласнаар халдварт өвчний гаралт буурч, 2024 оноос гоц халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.

Б.2 Мал эмнэлгийн газар нь шат шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд зөрчилтэй анхан шатны баримтаар 1,313.6 сая төгрөгийн үйлчилгээний хөлсийг олгосон байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Хавсралтууд

Холбогдох байгууллагын санал

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХӨА	Хөвсгөл Аймаг
ШТА	Шууд Тайлагнах Ажил
МЭНС	Мал Эмнэлгийн Нэгдсэн Систем
МЭҮН	Мал Эмнэлгийн Үйлчилгээний Нэгж
ХХААХҮЯ	Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрлэлийн Яам
МАЕГ	Мал Эмнэлгийн Ерөнхий Газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/31

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторовн 2024 оны А/108 дугаар тушаал, 2023 оны А/102 дугаар тушаалаар баталсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх заалт, Хөвсгөл айман дахь Төрийн аудитын газрын 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөөг”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн төлбөрийн актыг хоёрдугаар, албан шаардлагыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн ерөнхий газар, аймгийн Мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд тус тус хүргүүлсүгэй.

3. “Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнг 2026 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Б.Давааням/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудиторын 2025 оны 11 дүгээр сарын
10-ны өдрийн А/31 дүгээр тушаалын хоёрдугаар
хавсралт




“Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад зарцуулсан
хөрөнгийн зарцуулалт, үр дүн” нийцлийн аудитаар өгсөн төлбөрийн актын
жагсаалт

№	Төлбөрийн актын дугаар	Утга	Дүн төгрөгөөр
1	170/A2270469/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	3,484,300
2	169/A2270469/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	3,094,400
3	168/A2270469/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	2,303,800
4	167/A2270469/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	780,100
5	166/A2270469/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	3,803,800
6	165/A2270469/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	1,240,700
7	164/A2270469/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	792,000
8	143/A2271188ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	548,100
9	151/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	604,000
10	152/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	621,400
11	150/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	359,455
12	145/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	6,344,750
13	146/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	2,128,250
14	144/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	1,447,830
15	147/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	10,592,850
16	148/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	1,765,650
17	129/A2260439/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	1,280,230
18	131/A2260439/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	377,902
19	163/A2270469/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	414,800
20	162/A2270469/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	829,100
21	161/A2270469/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	650,400
22	155/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	2,836,110
23	154/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	227,689
24	153/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	2,576,800
25	134/A2271188ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	509,100
26	158/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	4,116,865
27	157/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	1,913,750
28	156/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	1,741,410
29	159/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	877,550
30	180/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	573,970
31	127/A2260439/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	4,826,288

32	128/A2260439/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	2,600,500
33	141/A2271188ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	1,020,300
34	140/A2271188ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	322,500
35	139/A2271188ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	822,200
36	138/A2271188ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	396,300
37	142/A2271188ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	454,300
38	149/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	2,282,480
39	133/A2260439/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	7,989,175
40	132/A2260439/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	1,770,920
41	171/A2270469/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	2,097,700
42	130/A2260439/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	1,013,536
43	137/A2271188ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	9,653,600
44	136/A2271188ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	24,422,950
45	135/A2271188ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	15,636,800
46	126/A2260439/ХӨА-2025/52-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	1,153,734
Нийт			135,300,400

--оо0оо--

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудиторын 2025 оны 11 дүгээр сарын
10-ны өдрийн А/31 дүгээр тушаалын гуравдугаар
хавсралт



“Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад
зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар
өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Албан шаардлагын дугаар	Утга	Дүн төгрөгөөр
1	106/A2260439/ХӨА-2025/52-ШТА-ГА	Хариуцлага тооцуулах тухай	-
2	107/A2270469/ХӨА-2025/52-ШТА-ГА	Хариуцлага тооцуулах тухай	1,313,449,800
3	108/A2271338/ХӨА-2025/52-ШТА-ГА	Хариуцлага тооцуулах тухай	-
4	109/A2271188/ХӨА-2025/52-ШТА-ГА	Хариуцлага тооцуулах тухай	-
5	110/A2270469/ХӨА-2025/52-ШТА-ГА	Зөрчил таслан зогсоох тухай	-
6	111/A2271188/ХӨА-2025/52-ШТА-ГА	Зөрчил таслан зогсоох тухай	-
Нийт			1,313,449,800

--oo0oo--

Аудитын нэр, код	“Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, үр дүн” гүйцэтгэлийн аудит /ХӨА-2025/52-ШТА-ГА/
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрх.
Аудитын зорилго	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, үр ашиг, үр дүнг үнэлж дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, олон нийтэд мэдээлэх
Зорилт	<ul style="list-style-type: none">• Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг бүс нутгийн онцлог, мал, амьтны тоонд нийцүүлэн үндэслэлтэй тооцож төлөвлөсөн эсэх;• Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулж, вакцинжуулалтын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх;
Хамарсан хүрээ	Аудитад аймгийн Засаг даргын Тамгын газар түүний хэлтсүүд, аймгийн Мал эмнэлгийн газар, сумдын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн хувийн аж ахуйн нэгжүүдийн малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022-2025 онд хийсэн үйл ажиллагаа, тарилгын зарцуулалтын анхан шатны баримт, төлөвлөгөө, гүйцэтгэл, дотоод хяналт, бусад холбоотой баримт материалуудыг хамруулсан. Хөвсгөл аймагт мал эмнэлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 74 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн тарилгын баримт материал.
Аудитын арга зүй	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторын А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгааны арга зүйг ашигласан
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд	<ul style="list-style-type: none">• Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль• Төрийн аудитын тухай хууль;• Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль,

	<ul style="list-style-type: none">• Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай хууль,• Монгол малчин үндэсний хөтөлбөр,• Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого,• Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл,• Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр• Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
Материаллаг байдал	<p>Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үр дүнг “дунд” эрсдэлтэй гэж үзэж материаллаг байдлын хувийг 1.5% байхаар тооцож гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2022-2024 онд улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан дүнгээс 207.7 сая төгрөгөөр тогтоосон.</p> <p>Аудитаар нийт 13 нэр төрлийн өвчнөөс түүвэрлэн 2024 онд гүйцэтгэсэн бог малын мялзан өвчний баримт материалыг шалгахад тухайн өвчлөлд зарцуулсан 1,244.4 сая төгрөгийн 10.9 хувь нь буюу 135.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.</p> <p>Листериоз, ДХХ, Цусан халдвар, Энтербактериоз, Колибактериоз, ДХХ, Цусан халдварын вакцинуудын давтан тунг тарьсан анхан шатны нотлох баримт байхгүй байхад нэг удаагийн тарилгын баримтын цувааг үндэслэн 2022-2024 онд 2 удаагийн үйлчилгээний хөлсөнд нийт 1,178.2 сая төгрөгийг олгосон зөрчил илэрсэн.</p> <p>2022-2024 онд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан нийт 13,843.1 сая төгрөгт шилжүүлэн тооцоход 1,313.5 сая төгрөг буюу 9.5 хувийн эрсдэлтэй байгааг илэрхийлж байна.</p>
Багийн бүрэлдэхүүн	<p>Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Давааням, аудитор Г.Ичинхорлоо, Б.Ариунтуяа, Ц.Чагнаадорж нар гүйцэтгэсэн. Аудитын цар хүрээнээс хамаарч 2024 оны бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын вакцинжуулалтын үйлчилгээний хөлс олгосон анхан шатны баримт материалд тулган баталгаажуулалт хийхэд Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүх аудиторыг татан оролцуулсан.</p>

Үндсэн мэдээлэл:

Мал аж ахуйн салбарын бодлогын 2020-2025 оны хөгжлийн хандлага, стратегийн зорилтод уламжлалыг хадгалсан бэлчээрийн аж ахуй, дэвшилтэт технологи бүхий эрчимжсэн аж ахуйг хослуулан хөгжүүлж, нөөцийг тогтвортой, зохистой ашиглан ногоон эдийн засгийн чиг баримжааг дэмжихэд суурилна гэж тодорхойлсон.

Энэ хүрээнд Малын халдварт өвчинтэй тэмцэж, эрүүл бүсийг бий болгох, гоц халдварт зарим өвчнөөр тайван бүсийн статусыг хангах, мал эмнэлгийн ажил, үйлчилгээ, тогтолцоог олон улсын жишигт хүргэх, малын эм, хэрэгслийн үйлдвэрлэлд үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлж, малын эм, био бэлдмэлийн бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн Засаг даргын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөрт “Мал, амьтны халдварт,

гоц халдварт, шимэгч өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, гоц халдварт өвчингүй тайван бүс нутгаа баталгаажуулна” гэсэн зорилтын хүрээнд 3 арга хэмжээг төлөвлөн баталж хэрэгжүүлсэн байна.

Хөвсгөл аймаг 2024 онд 5,163.2 мянган толгой мал тоолуулж улсын малын тоогоор тэргүүлсэн үзүүлэлттэй байна.

Малыг халдварт болон гоц халдварт өвчнөөс сэргийлэх хүрээнд малын гоц халдварт өвчний тарилгын зардлыг улсын төсөвт, халдварт өвчний тарилгын зардлыг орон нутгийн төсөвт тусган баталж хэрэгжүүлсэн байна.

Халдварт өвчнөөс сэргийлэх вакцины тээвэрлэлт, хадгалалтыг аймгийн МЭГ, сумын мал эмнэлгийн тасаг хариуцаж, тарилгыг мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн аж ахуйн нэгжүүд гүйцэтгэдэг байна.

Сангийн сайд, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2021 оны А/118, А/201 дугаар тушаалаар баталсан улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативын зарим тарифт 2024 оны А/116, А/418 дугаар тушаалаар өөрчлөлт оруулан байна.

Хөвсгөл Аймгийн ИТХ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Мал эмнэлгийн үйлчилгээний зардлын жишиг үнийг аймгийн ИТХ-ын 2024 оны XXVII/30 тогтоолоор хүчингүй болгож шинэчлэн тогтоосон байна.

Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2022-2024 онд улсын болон орон нутгийн төсвөөс нийт 13,849.0 сая төгрөгийг олгосон байна.

Хөвсгөл аймагт 2022-2024 онд нийт 110.5 мянган мал амьтан халдварт өвчнөөр өвчилж, 915 мал хорогдсон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Он	Өвчилсөн	Хорогдсон	Эдгэрсэн	Устгасан	Шинж тэмдэг арилсан
Гоц халдварт өвчин					
2022	108,351	114	-	13	108,224
2023	1,439	369	-	-	1,070
Дүн	109,790	483	-	13	109,294
Халдварт өвчин					
2022	127	100	23	4	-
2023	548	295	251	2	-
2024	65	37	6	22	-
Дүн	740	432	280	28	-
Нийт дүн	110,530	915	280	41	109,294

Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газар нь мал амьтны эрүүл мэндийн алба, захиргаа санхүүгийн алба, мал эмнэлгийн лаборатори гэсэн 3 албатай, 58 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчаар нийт 26 албан хаагч ажиллаж байна. Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газар нь малын халдварт өвчнөөс урьдчилан

сэргийлэх үйл ажиллагааг сумдын мал эмнэлгийн тасаг болон гэрээт 74 мал эмнэлэгтэй хамтран зохион байгуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

БҮЛЭГ-А. Аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж хэрэгжүүлэн ажилласнаар халдварт өвчний тохиолдол буурсан байна.

А.1 Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан холбогдох журам, стандартаар малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг оновчтой тодорхойлсон байна.

А.1.1 Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль нь мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, өвчингүй, тайван улс, бүс, нутаг, хамгаалалттай аж ахуй, хот айл, аж ахуйн нэгжийг тогтоон баталгаажуулах үйл ажиллагаа, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн үзлэг, лабораторийн шинжилгээ, мал эмнэлэг, хорио

цээр, хязгаарлалтын хяналт, шалгалттай холбогдох харилцаанд үйлчлэх зохицуулалттай байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гэдэг нь өвчний гаралт, тархалтад нөлөөлж байгаа хүчин зүйлийг арилгах зорилгоор хийгдэх үзлэг, тандалт, халдваргүйтгэл, дархлаажуулалт, нүүлгэн шилжүүлэлт, шилжилт хөдөлгөөний хяналт зэрэг мэргэжлийн үйл ажиллагааг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах хууль болон түүнтэй уялдуулан гарсан журам заавар, стандартад нэгдсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх бүтэц, тэдгээрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон хяналтын тогтолцоог хууль тогтоомжоор бүрэн тодорхойлсон байна.

Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр тодорхойлсон хууль эрх зүйн заалтуудаас бодит байдалд хэрэгжихгүй байгаа зарим заалтуудыг хүснэгтээр харуулбал:

Хууль эрх зүйн заалт	Бодит нөхцөл байдал
Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн “30.10.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч тухайн нутаг дэвсгэрт байнга болон түр хугацаагаар үйлчилгээ үзүүлж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг өөрөө сонгон үйлчлүүлэх эрхтэй”	Мал бүхий иргэдийн оршин сууж байгаа баг тус бүрээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд шууд хуваарилсан, малчид өөрсдөө сонгох нөхцөл бүрдээгүй байгаа нь харагдаж байна.
Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартад 1 малын эмчид ногдох малын тоо хонин толгойд шилжүүлснээр (40.000) байна.	Бодит байдал дээр 1 малын эмчид ногдох малын тоо хонин толгойд шилжүүлснээр (140.000) орчим байна.
Өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт малд дархлаажуулалт хийсэн малын эмч бүртгэл хөтөлж, тэмдэглэл хийнэ гэсэн заалтыг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өөрчлөлт оруулан хүчингүй болгосон.	“Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журам” болон Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандарт-д мал амьтны эрүүл мэндийн дэвтэрт үзлэг, дархлаажуулалт хийсэн тухай бүр бичилт хийж, тэмдэглэл хийнэ гэж заасан боловч тэмдэглэл хийж хэвшээгүй байна.

Хүснэгтээс харахад:


- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч тухайн нутаг дэвсгэрт байнга болон түр хугацаагаар үйлчилгээ үзүүлж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг өөрөө сонгон үйлчлүүлэх эрхтэй гэж заасан боловч малчид өөрсдөө аж ахуй нэгжээ сонгох нэгдсэн арга хэмжээ авдаггүй бөгөөд малчид өөрсдөө санал хүсэлт гаргаж хэвшээгүй байна.
- Нэг малын эмчид ногдох малын тоо стандартаас 100.0 мянга орчмоор хэтэрсэн.
- Өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт малд дархлаажуулалт хийсэн малын эмч бүртгэл хөтөлж, тэмдэглэл хийж хэвшээгүй байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон түүнтэй уялдуулан гарсан журам заавар, стандартад нэгдсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх бүтэц, тэдгээрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон хяналтын тогтолцоог хууль тогтоомжоор бүрэн тодорхойлсон байна

A.1.2 Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тогтолцоо нь улсын хэмжээнд мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллага, аймаг, нийслэлд мал эмнэлгийн байгууллага, лаборатори, сум, дүүрэгт мал эмнэлгийн тасаг, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс бүрдэнэ гэж заасан байна.

Аймгийн мал эмнэлгийн газар нь малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны нэгдсэн бодлого арга зүй, шаардагдах хөрөнгө, санхүүгээр хангах ажлыг хэрэгжүүлж, мал эмнэлгийн тасгийн хяналтын улсын байцаагчид нь гэрээт 74 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын дархлаажуулалтын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэн ажиллах.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог тусгасан бөгөөд бүтцийн нэгжүүдийг схемээр харуулбал дараах байдалтай байна.



Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд мал эмнэлгийн газрын болон бусад эрх бүхий албан тушаалтны чиг үүргийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- **Мал эмнэлгийн газрын чиг үүрэг:** Нутаг дэвсгэрийн хэмжээнд тандалт судалгаа хийж мэдээллийн сан бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэл үр дүнг хянах гэж тодорхойлсон байна.
- **Мал эмнэлгийн тасгийн гүйцэтгэх үйл ажиллагаа:** МЭҮН-үүдийн ажил үйлчилгээг хугацаа хоцроох, чанаргүй гүйцэтгэсэн байдалд албан шаардлага, зөвлөмж өгч гүйцэтгэлд хяналт тавих, зөрчлийг илрүүлэн хуулийн дагуу хянан шийдвэрлэх.
Дархлаажуулалтын технологийн хяналтыг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, үр дүнгийн хяналтыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори, шаардлагатай тохиолдолд улсын мал эмнэлгийн лаборатори хэрэгжүүлэх зохицуулалттай байна.
- **Сумын засаг даргын гүйцэтгэх үйл ажиллагаа:** Мал эмнэлгийн бүх төрлийн технологит ажил үйлчилгээг графикт хугацаанд нь зохион байгуулах, Засаг даргын захирамж гаргуулан нийт мал сүргийг хамарсан дархлаажуулалт, эрүүл мэндийн

тусламж үйлчилгээнд хүн хүч, хөрөнгө, санхүү, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлд хяналт тавин ажиллах, хорио цээрийн дэглэм тогтоох.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд мал амьтны дархлаажуулалтын товыг мал эмнэлгийн тасаг тогтоож, багийн Засаг дарга малчин, амьтан маллагчид зарлан мэдээлэх мөн халдварт өвчний онош илэрсэн тохиолдолд, сум дүүргийн засаг дарга аймгийн мал эмнэлгийн байгууллагад мэдэгдэх, хорио цээрийн, хязгаарлалт тогтоон ажилласан байна.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг гүйцэтгэгч 74 мал эмнэлийн үйлчилгээний нэгжийн дархлаажуулалтын үйл явцад сумдын мал эмнэлгийн тасгийн албан хаагчид технологийн, аймгийн мал эмнэлгийн газар үр дүнгийн хяналтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон түүнтэй уялдуулан гарсан журам, заавар, стандартад нэгдсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэх бүтэц, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий албан тушаалтнуудыг хууль тогтоомжоор бүрэн тодорхойлсон байна

А.2 Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газар нь малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн төлөвлөж хэрэгжүүлэн ажилласнаар халдварт өвчний тохиолдол буурсан байна.

А.2.1 “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн Бүсчилсэн хөгжлийн 8.1.3-д “...малын өвчингүй эрүүл, халдваргүй бүс нутаг болгоно” гэсэн заалттай нийцүүлэн Хөвсгөл аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

№	Бодлогын баримт бичгүүд	Заалт	Зорилт
1	Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	8.4.3	“Мал, амьтны гоц халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гоц халдварт өвчингүй тайван бүс нутгаа баталгаажуулна”
2	Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	3.2.6	“Мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, гоц халдварт өвчингүй тайван бүс нутгаа баталгаажуулна”
3	Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2.3.2	“Мал, амьтны өвчний голомт, тандалт, тархвар зүйн судалгааг үндэслэн халдварт, шимэгчлэх, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх”

Дээрх хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа хийх, тэмцэх арга хэмжээнд мал, амьтныг хамруулна.
- Шимэгчлэх өвчинтэй тэмцэх, эмчлэн сэргийлэх арга хэмжээнд мал, амьтныг хамруулна.
- Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын байдалтай уялдуулан халдваргүй өвчний эм бэлдмэлийн нөөц бүрдүүлэх, зүй бусаар хорогдсон малын сэг зэмийн устгал хийх ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулах.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь Хөвсгөл аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн байна.

А.2.2 Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газар нь аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө мал амьтныг хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг тусган байна. Үүнд: /2022-2025/

- Орон нутгийн хөгжлийн төлөв байдлыг тодорхойлж, үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах бодлогыг хэрэгжүүлэх
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих.
- Нийтийн эрүүл мэнд хүнсний аюулгүй байдлыг хангах
- Лабораторийн оношилгоо шинжилгээ, хийж малын өвчний шалтгааны тодорхойлох
- Мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, ерөнхий болон тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх
- Малын халдварт өвчний тандалт судалгаа хийх
- Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх, зохион байгуулах зэрэг араг хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан байна.

А.2.3 Хөвсгөл аймаг 2022 онд 6,254.1 мянга, 2023 онд 5,662.0 мянга, 2024 онд 5,163.2 мянган толгой мал тоолуулсан бөгөөд тус онуудад нийт 110.5 мянган толгой мал, амьтан халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022-2024 онд нийт 21,550.1 мянган толгой малыг хамруулахаар тооцож төлөвлөсөн байна. Үүнд:

- 2022 онд 5,147.3 мянган толгой мал
- 2023 онд 8,094.9 мянган толгой мал
- 2024 онд 8,308.1 мянган толгой мал

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөхдөө малын тоо толгой, малын халдварт өвчний тохиолдол бүрээр нь тооцон гаргасан сүүлийн 20 жилийн судалгаанд үндэслэн тооцож төлөвлөсөн байна.

Хөвсгөл аймагт 2021 оны 12 дугаар сард шүлхий өвчний тохиолдол бүртгэгдэн тархалт дэгдсэн байна. Аймгийн хэмжээнд тус өвчний тархалтыг зогсоох яаралтай арга хэмжээг зохион байгуулж ажиллан 2021 онд 243.7 мянган толгой мал, 2022 онд 1,305.8 мянган толгой малыг тус тус вакцин, дархлаажуулалтад хамруулж өвчний дэгдэлтийг бүрэн зогсоосон бөгөөд 2023-2024 онд өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.

Бог малын мялзан өвчний тухайд 2022 онд 0.5 мянган толгой мал, 2023 онд 1.4 мянган толгой мал тус тус өвчилсөн байна. Бог малын мялзан өвчний тархалтыг зогсоох урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2022 онд 88.2 мянган толгой мал, 2023 онд 3,529.0 мянган толгой малыг дархлаажуулалтад хамруулснаар өвчний тархалтыг арилгасан бөгөөд 2024 онд өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.

Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газар нь аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан мал амьтныг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилт арга хэмжээнд нийцүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажилласнаар малын халдварт өвчний тохиолдол буурсан байна.

А.3 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг малын тоо, өвчний тархалтад үндэслэн тооцож төлөвлөсөн байна.

А.3.1 Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газар нь малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тарилгын үйлчилгээний хөлсөнд 2022-2025 онд улсын төсвөөс 2,674.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 2,076.8 сая төгрөг нийт 4,751.7 сая төгрөгийг олгохоор тооцож төлөвлөсөн төсвийн санал хүргүүлсэн байна.

Мал, амьтны гоц халдварт өвчин буюу Шүлхий, Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсийг МЭЕГ-аас аймгийн малын тоонд үндэслэн шууд хуваарилж байгаа тул мал эмнэлгийн газар нь төсвийн саналдаа тусгадаггүй байна.

Орон нутгийн төсвийн санхүүжилтийг 2022-2024 онд 2,076.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн ЗДТГ-ын санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна. Тус саналаас 732.0 сая төгрөгийг хасаж нийт 1,344.8 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн ИТХ-ын тогтоолоор баталж олгосон байна.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг малын тоо толгой, өвчний судалгаанд үндэслэн тооцож төлөвлөсөн боловч орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг бууруулан баталсан байна.

Аймгийн Мал эмнэлгийн газар нь малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, вакцин, тарилгын үйлчилгээний хөлсийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн тарилгын гүйцэтгэлд үндэслэн олгож байна.

Малын гоц халдварт Шүлхий, Бог малын мялзан өвчний вакцин, тарилгын үйлчилгээний хөлсийг МЗЭГ-аас малын тоонд үндэслэн шууд хуваарилан гүйцэтгэлээр санхүүжүүлж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх дархлаажуулалтын зардлыг өвчний тархалт, малын тоонд үндэслэн тооцож төлөвлөсөн байна.

БҮЛЭГ Б. Мал эмнэлгийн газар нь шат шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд зөрчилтэй анхан шатны баримтаар 1,313.6 сая төгрөгийн үйлчилгээний хөлсийг олгосон байна.

Б.1 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажилласнаар халдварт өвчний гаралт буурч, 2024 онд гоц халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.

Б.1.1 Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газар нь 3 албатай, 58 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнийг диаграммаар харуулбал:




Хөвсгөл аймагт мал, амьтны эрүүл мэндийн салбарт ажиллаж буй малын их эмч, мэргэжилтнүүдийн хувьд Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид хамаарах 75, Мал эмнэлгийн газар, мал эмнэлгийн тасагт 48, нийт 123 эмч ажиллаж байна.

Орон нутагт дараах тогтолцоогоор мал амьтны эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагааг явуулж байна.



Хөвсгөл аймагт мал амьтны эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаанд оролцогчид.



Олон улсад 1 малын эмчид ноогдох малын тоо 10 мянга байдаг бол Монгол улсад мөрдөгдөж буй Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартад зааснаар нэг малын эмчийн хариуцах малын тоог /хонин толгойд шилжүүлснээр/ 40 мянга гэж заасан байдаг бол 2024 онд Хөвсгөл аймагт 1 малын эмчийн хариуцах малын тоо 140 мянга орчим байгаа нь Олон улсад 1 малын эмчийн хариуцаж буй тооноос 130 мянгаар илүү, монгол улсад мөрдөж буй стандартаас 100 мянган толгой малаар илүү хуваарилагдаж байгаагаас харвал 2022-2025 онуудад Хөвсгөл аймгийн хэмжээнд Мал эмнэлгийн салбар нь ажиллах боловсон хүчний дутагдалд ороод буй нь харагдаж байна.

Мөн мал амьтны эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгаа боловсон хүчний насны хувьд 60-аас дээш хувь нь 50-аас дээш насныхан байдаг бөгөөд Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн захирлуудтай хийсэн уулзалтаар бага эмч болон техникийн ажилтны цалин хангамж муу, нийт ажилчдын ажлын нөхцөл хүнд, хөдөө орон нутагт суурьшин ажиллах зэрэг шалтгаануудаас залуучууд малын эмчийн мэргэжлээр сурах, ажиллах сонирхолгүй байдаг талаар дурдаж байна.

Тулгамдаж буй хүний нөөцийн асуудлын хүрээнд дараах ажлыг зохион байгуулсан байна. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газраас 2024, 2025 онд 12 дугаар ангийн сурагчдад мал эмнэлгийн чиглэлийн ажил мэргэжлийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан.
2. Салбарын боловсон хүчний хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын тэтгэлгээр ОХУ-ын Буриад улсад 16 оюутныг мал эмнэлгийн чиглэлээр сургах ажлыг санаачлан зохион байгуулсан байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд 1 малын эмчид ногдох малын тоо стандартаас (100.0 мянга)-аар хэтэрсэн байгаа нь малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байгааг илтгэж байна.

Б.1.2 Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газарт малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023-2024 онд дараах хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийсэн байна. Үүнд:

- 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ХХААХҮЯ-ны Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрөөс 1,445.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Үүнд: Мал эмнэлгийн дуудлага үйлчилгээнд 19 ширхэг Пробокс машин, гоц болон халдварт өвчний ариутгал, халдваргүйтгэлийг гүйцэтгэх 15 ширхэг ДУК машин, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр мал эмнэлгийн лабораторид оношилгоо шинжилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор 43.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.
- 2025 онд Олон улсын төслийн санхүүжилтээр Мал аж ахуйн эзэн төслөөс төсөл хэрэгжүүлсэн 5 сумын 10 аж ахуйн нэгжийн үйлчилгээг дэмжих, чадавхжуулах

зорилгоор 61.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтуудыг тус тус хийсэн байна.

Дээрх хөрөнгө оруулалтууд хийгдсэнээр мал эмнэлгийн салбарын машин техник, тоног төхөөрөмжийн дутагдалгүй, үйл ажиллагааг доголдолгүй, хэвийн явуулах нөхцөлөөр бүрэн хангагдсан байна.

Мал амьтны вакцины нийлүүлэлтийг МЭЕГ хариуцан хэрэгжүүлдэг бөгөөд аймгийн мал эмнэлгийн газар нь тус вакциныг лабораторийн хөргүүрт хүлээн авч сумдын мал эмнэлгийн тасагт хуваарилах, шаардлагатай тохиолдолд мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд хүлээлгэн өгөх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд шаардагдах тоног төхөөрөмжийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартын 6.3.6-д “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь халдвар хамгааллын дэглэмийн чанд сахиж ажиллахын зэрэгцээ ариутгал халдваргүйтгэл хийх багаж хэрэгсэл, халдваргүйтгэлийн бэлдмэлийн нөөцийг тусгай сав, агуулахад хадгална” 7.1.7-д “Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгж тус бүр дараах тоног төхөөрөмжтэй байна” гэж заасан байна. Үүнд:

- Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний зориулалт бүхий суурин болон зөөврийн хашаа,
- Вакцин зөөвөрлөж, тээвэрлэх зориулалттай бага оврын хөргүүр,
- Мал угаалгын суурин эсхүл, зөөврийн ванн, төхөөрөмжтэй байна гэж заасан байна.

Дээрх стандартын дагуу Мал эмнэлгийн газар, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд нь малын вакцинжуулалтыг хэрэгжүүлэх хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах вакцин тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгсэл, хадгалах агуулах, нэгдсэн хөргүүр, сум багуудад зөөх жижиг оврын хөргүүр, техник, тоног төхөөрөмжүүдээр бүрэн хангагдсан байна.

Б.1.3 “Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль” болон “Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журамд “Мал, амьтны халдвар, шимэгчлэх, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эмчлэх арга хэмжээний технологи, гүйцэтгэл үйл ажиллагаанд байнгын хяналт хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчид нь албан үүргээ хангалттай хэрэгжүүлж ажиллаагүйгээс дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчид нь Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын үйл ажиллагаанд шат шатны хяналтыг бодитой хэрэгжүүлээгүйгээс анхан шатны баримтыг хуурамчаар үйлдсэн, засвар оруулсан, тамганы нэр зөрүүтэй, бүдэг тамга дарсан, тамгаар баталгаажуулаагүй байхад вакциныг технологийн дагуу тарьж гүйцэтгэсэн гэж дүгнэлт гаргасан байна.

Дээрх зөрчил нь Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6¹ дэх заалт, “Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журмын 2.2² дахь заалттай тус тус нийцэхгүй байгаа тул хяналт хэрэгжүүлж ажиллаагүй мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нарт **сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага** хүргүүлж шийдвэрлэсэн. /Гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоосон. Тухайн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын 2024 оны санхүүжилтийн зөрчлийн дүн нь 1.5 хувиас хэтэрсэн хяналт тавих чиг үүрэг бүхий хяналтын улсын байцаагч нарт хариуцлага тооцуулах./

¹ “Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9, 10.12-т заасан нийтлэг эрх, үүргээс гадна дараах эрх, үүрэгтэй байна

² “Мал, амьтны халдвар, шимэгчтэх, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эмчлэх арга хэмжээний технологи, үйл ажиллагаанд байнгын хяналт хэрэгжүүлнэ”

Мал эмнэлгийн газрын дарга, улсын ахлах байцаагч нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүйгээс малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дараах зөрчлүүд үүссэн байна. Үүнд:

1. Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангаж ажиллаагүй,
2. Сумдын Засаг дарга, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн гэрээнд хяналт хэрэгжүүлж, гэрээг заалт бүрээр нь бодитой дүгнэдэггүй,
3. Вакцины давтан тунг тарьсан анхан шатны нотлох баримт үйлдээгүй байхад нэг удаагийн тарилгын баримтын цувааг үндэслэн үйлчилгээний хөлсийг тооцож олгосон,
4. Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс 2024 онд гүйцэтгэсэн Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын анхан шатны баримтыг хуурамчаар үйлдсэн, засвар оруулсан, тамганы нэр зөрүүтэй, бүдэг тамга дарсан, тамгаар баталгаажуулаагүй зэрэг зөрчилтэй байхад үйлчилгээний хөлсийг бүрэн тооцож, олгосон,
5. Мал эмнэлгийн газрын улсын ахлах байцаагчийн хяналт хангалтгүйгээс мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй холбоотой зөрчлүүд илэрч байна. Үүнд:
 - Цагаан-Уул сумын “Бүрэнтөгс хайрхан” ХХК нь малын их эмчгүй байхад хамтран ажиллах гэрээ байгуулж, үйлчилгээний хөлс, вакцинаар хангасан,
 - Цагаан-Уул сумын “Буман цагаан” хоршоо нь тухайн сумын улсын байцаагчийн хариуцсан аж ахуйн нэгж байхад гэрээ байгуулж, хяналт хэрэгжүүлж арга хэмжээ аваагүй,
 - Алаг-Эрдэнэ сумын тархвар зүйчээр ажиллаж байсан Д.Янжинлхам нь 2025 оны 2 дугаар сард ажлаас гарч “Ноён хошуу” ХХК-г худалдан авсан байхад гэрээ байгуулж, ажил гүйцэтгүүлсэн,

Дээрх зөрчлүүд нь Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4³ дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-457 дугаар тушаалаар баталсан “Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журам”-ын 5.3.4⁴ дахь заалт Мал эмнэлгийн газрын улсын ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтын 3-р зорилтын 3.1⁵ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. **Мал эмнэлгийн газрын дарга, Улсын ахлах байцаагч Л.Ариунаад сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн/**

Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчид нь хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байгаагаас, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үр дүнг бууруулж байгаа бөгөөд алслагдсан бүс нутгийн малчдын малыг вакцинжуулалтад бүрэн хамруулахгүй байх, тарилгын технологийг алдагдуулах зэрэг эрсдэлийг үүсгэж байна.

Б.1.4 Монгол улсын хэмжээнд Боом, Галзуу, Листерия, Штам, Рев, Шүлхий, Бог малын мялзан зэрэг 7 төрлийн өвчний вакциныг улсын төсвөөс, Цусан халдварт, Дотрын халдварт хордлого, ДХХ-Энтеробактериоз, Тугалын иж балнад, Дуут хавдар гэсэн 6 төрлийн вакциныг орон нутгийн төсвөөс, нийт 13 нэр төрлийн өвчний тарилгыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн үнэ төлбөргүй хийж байгаа бол Шөвөг яр, Сахуу гэсэн 2 нэр төрлийн вакциныг төлбөртэй гүйцэтгэдэг байна.

³ “Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мал эмнэлгийн салбарын бүх шатны байгууллага, лаборатори, мал эмнэлгийн тасаг болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн удирдлага, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллана”;

⁴ “Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналт хэрэгжүүлэх эрх бүхий улсын /ахлах/ байцаагч нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.13-30.17, 30.22-30.23, 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт заасан хяналтыг хэрэгжүүлнэ”;

⁵ “Хариуцсан нутаг дэвсгэрт мал эмнэлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААН, иргэнийг мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангаж, хяналт тавьж ажиллах, холбогдох байгууллагатай хамтран хяналт шалгалт явуулах”;

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд малчин, амьтан маллагчийн хүлээх үүргийг дараах байдлаар зааж өгсөн байна. Үүнд: 6 дугаар зүйл 6.5 “Зайлшгүй шаардлагаар хэрэгжүүлэх мал эмнэлгийн арга хэмжээнд мал, амьтнаа тогтоосон хугацаанд хамруулаагүйгээс бусдад учирсан хохирол болон уг арга хэмжээг нөхөн хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлыг мал, амьтан өмчлөгч хариуцна”, 9 дүгээр зүйл 9.8.1 “товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж, бүрэн хамруулах”; 9.8.2. “мал, амьтныг барьж бэхлэн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангах” гэж заасан байна.

Малчдын хувьд мал амьтнаа хамруулах эрэлт ихтэй вакцинуудын төрөлд Цусан халдварт, Боом, Дотрын халдварт хордлого зэрэг нэр төрлийн вакцинуудад байдаг ч тоо, ширхгийн хувьд нийт мал сүргийг хамруулах боломжгүй цөөн тоогоор хуваарилагддаг байна.

Малчдаас төлбөр авч хийдэг тарилгын хувьд, ихэвчлэн мал амьтан нь өвчилсөн тохиолдолд л малчид тухайн 2 нэр төрлийн тарилгыг хийлгэдэг ба урьдчилан сэргийлэх зорилгоор уг тарилгыг хийлгэдэггүй бол улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр үнэ төлбөргүй хийгддэг тарилгад малчид малаа хамруулж хэвшсэн байна.

Б.1.5 Монгол улсын ЗГ-ын 2018 оны 225 дугаар тогтоолоор “Мал амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаал”-ыг баталж, Монгол Улсын нутаг дэвсгэрт оношлогдох мал амьтны гоц халдварт, халдварт өвчнийг тогтоохдоо хүний амь нас хохирох эрсдэл үүсгэдэг 18 нэр төлийн, дотоодын худалдаанд хориг саад үүсгэдэг 27 нэр төрлийн, бусад халдварт өвчинд 23 нэр төрлийн өвчнийг нэрлэн баталсан байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд гоц халдварт өвчний бүртгэлд бүртгэгдсэн өвчнүүдээс 2021 онд Шүлхий, 2022 онд Шүлхий, Бог малын мялзан өвчин, 2023 онд Бог малын мялзан өвчин тус тус бүртгэгдсэн байна.

Шүлхий өвчний тохиолдол 2021 оны 12 дугаар сард Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Сангийн далай багт анх бүртгэгдсэнээс хойш 2022 оны 05 дугаар сар хүртэл хугацаанд тухайн өвчний тархалт нийт 20 сумын 26 голомтод 1,481 өрхийн 107,890 мал шүлхий өвчнөөр өвчилсөн, мөн тухайн онд Бог малын мялзан өвчний анхны тохиолдол Рашаант суманд анх бүртгэгдэж өвчлөл 3 сумын нутаг дэвсгэрт 461 толгой малыг хамран тархсан байна.

Шүлхий болон Бог малын мялзан өвчнийг бүртгэгдсэн даруйд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын А/187 дугаар тушаалаар баталсан “Шүлхий өвчинтэй тэмцэх заавар”, “Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар”-ын дагуу түрэн шуурхай арга хэмжээ авч ажилласан байна.

Шүлхий өвчний гаралттай холбогдуулан Аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 03-ын өдрийн А/598 дугаар захирамжаар “Гоц халдварт шүлхий өвчний эсрэг хариу арга хэмжээ авах тухай”, 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/604 дугаар захирамжаар “Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох тухай”, аймгийн Онцгой комиссын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 26 хуралдаан, Улсын нэгдсэн шуурхай штабаас 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн “Цаг үеийн нөхцөл байдлын шуурхай хуралдаан”, Бүрэнтогтох сумын Засаг даргын А/155 “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” тушаал, А/159 “Дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай” тушаал болон холбогдох шийдвэрүүдийг тухай бүр гарган, холбогдох байгууллагуудтай шуурхай хамтран ажиллаж, гоц халдварт өвчний тархалтыг 2022 оны 05 дугаар сард бүрэн зогсоож ажилласан, бөгөөд Хөвсгөл аймгийн хэмжээнд бүх үхэр сүргийг хавар, намрын дархлаажуулалтад хамруулж, яаралтай дархлаажуулалтыг 7 удаа зохион байгуулж ажилласан байна.

Бог малын мялзан өвчин 2023 онд Хөвсгөл аймгийн 6 сумын 7 голомтот газарт 1,439 толгой мал өвчилж 2023 оны 07 дугаар сард өвчний гаралтыг зогсоож хязгаарлалтын дэглэмийг цуцалсан байна.

Хөвсгөл аймагт өвчилсөн малын тоог нийт малын тоонд харьцуулан харуулбал:

Он	Хөвсгөл аймгийн малын тоо	Өвчилсөн малын тоо	Нийт малын тоонд эзлэх өвчлөлийн хувь
2022	6,254,100	108,478	1.73
2023	5,662,000	1,987	0.04
2024	5,163,200	65	-

Хүснэгтээс харахад нийт малын тоонд харьцуулсан өвчлөлийн хувь 2022 онд 1.7, 2023 онд 0.04 хувь, 2023 онд 0 хувьд хүргэсэн байна.

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газраас 2022, 2023 онуудад 20 сумын 109,790 толгой малыг хамарсан гоц

халдварт өвчний гаралтын үед өвчний цар хүрээг хумьж, тархалтыг барих, шуурхай арга хэмжээ авч, цаашид урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажилласнаар малын өвчлөл, хорогдол багатайгаар даван туулах нөхцөлийг бүрдүүлж, гоц халдварт өвчлөлийн тархалтыг бүрэн зогсоож ажилласан байна.

Мал, амьтныг 2022-2024 онд өвчилсөн өвчний нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

№	Өвчний нэр	Өвчилсөн	Үүнээс			
			Хорогдсон	Эдгэрсэн	Устгасан	Шинж тэмдэг арилсан
1	Галзуу	37	29	-	8	-
2	Боом	6	3	-	3	-
3	Листерияоз	118	44	70	4	-
4	Цусан халдварт	119	68	38	13	-
5	Дотрын халдварт хордлого	134	131	3	-	-
6	Энтеробактериоз	50	42	8	-	-
7	Колибактериоз	276	115	161	-	-
8	Шүлхий	107,890	-	-	1	107,889
9	Бог малын мялзан	1,900	483	-	12	1,405
Дүн		110,530	915	280	41	109,294

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2022-2024 онд нийт 110,530 толгой мал амьтан халдварт өвчнөөс өвчилснөөс хорогдсон 915, эдгэсэн 280, устгасан 41, шинж тэмдэг арилсан 109,294 тохиолдол бүртгэгдсэн байна.

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар нь гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажилласнаар 2022-2024 өвчний тохиолдол огцом буурсан үзүүлэлттэй байна.

Б.2 Мал эмнэлгийн газар нь шат шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд зөрчилтэй анхан шатны баримтаар 1,313.6 сая төгрөгийн үйлчилгээний хөлсийг олгосон байна.

Б.2.1 Төсвийн санхүүжилт: Мал эмнэлгийн газар нь 2022–2024 онд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын болон орон нутгийн төсвөөс нийт 13,849.1 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна. Үүнд:

- Үйлчилгээний хөлсөнд 7,293.2 сая төгрөг,
- Вакцины зардалд 6,378.1 сая төгрөг,
- Тандалт мониторингийн зардалд 177.8 сая төгрөг.


Санхүүжилтийг хүлээн авсан огноогоор нь задлан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөг/

	Үзүүлэлт	Үйлчилгээний хөлс	Вакцин	Тандалт	Нийт дүн
2022	Улсын төсөв	699,262.3	1,329,176.5	31,970.4	2,060,409.2
	Орон нутгийн төсөв	468,458.5	157,183.1	22,132.5	647,774.1
	Нийт	1,167,720.8	1,486,359.6	54,102.9	2,708,183.3

2023	Улсын төсөв	2,254,388.4	2,555,989.7	33,778.0	4,844,156.1
	Орон нутгийн төсөв	431,794.7	223,203.0	12,473.5	667,471.2
	Нийт	2,686,183.1	2,779,192.7	46,251.5	5,511,627.3
2024	Улсын төсөв	2,994,715.8	1,784,871.5	73,807.7	4,853,395.0
	Орон нутгийн төсөв	444,548.5	327,661.6	3,624.2	775,834.3
	Нийт	3,439,264.3	2,112,533.1	77,431.9	5,629,229.3
2022-2024 оны нийт санхүүжилт		7,293,168.2	6,378,085.4	177,786.3	13,849,039.9

Хүснэгтээс харахад малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал жил бүр өссөн байдалтай байна. Үүнийг графикаар харуулбал:



Графикаас харахад 2023 оны санхүүжилт өмнөх оноос 2 дахин өссөн нь 2022 оны жилийн эцэст малын гоц халдварт өвчин болох шүлхий өвчний дэгдэлт гарч мал амьтдыг масс вакцинд хамруулсан нь нөлөөлсөн байна. Тус вакцинжуулалтын санхүүжилт болох 271.8 сая төгрөгийг 2023 онд олгосон, мөн 2023 онд бог малын мялзан өвчний дэгдэлт гарч масс вакцинжуулалтын үйлчилгээний хөлсөнд

882.2 сая төгрөгийг олгосон зэрэг нь санхүүжилт өсөхөд нөлөөлсөн байна.

Санхүүжилтийн 2024 оны өсөлт нь Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2024 оны А/116, А/418 дугаар “Мал эмнэлгийн үйлчилгээний зарим зардлын норматив батлах тухай тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тушаалаар үйлчилгээний хөлсний тарифыг шинэчлэн баталсантай холбоотой байна.

Мал эмнэлгийн газар нь 2022-2024 онд улсын болон орон нутгийн төсвөөс олгож буй санхүүжилтийг бүрэн хүлээн авсан байна.

Б.2.2 Төсвийн зарцуулалт:

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 2022-2024 онд нийт 18,193.5 мянган толгой малыг дархлаажуулалтад хамруулахад 13,843.2 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 6.0 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	1.Үйлчилгээний хөлс	2.Тандалт	3.Вакцин	Нийт зардал
2022	1,163,888.9	54,102.9	1,486,359.6	2,704,351.4
2023	2,684,980.2	46,251.5	2,779,192.7	5,510,424.4
2024	3,438,364.8	77,431.9	2,112,533.1	5,628,329.8
Нийт дүн	7,287,233.9	177,786.3	6,378,085.4	13,843,105.6

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгосон үйлчилгээний хөлсний талаар:

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд 2022-2024 онуудад нийт 7,287.2 сая төгрөгийн үйлчилгээний хөлсийг олгосон байна. Аудитаар нийт таригдсан малын тооны гүйцэтгэлийг үндэслэн олговол зохих үйлчилгээний хөлсийг тооцоолж, олгосон үйлчилгээний хөлстэй харьцуулж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт	Олговол зохих үйлчилгээний хөлс	Өмнөх оны өр	Олгосон үйлчилгээний хөлс	Тайлант жилийн өрийн үлдэгдэл	Илүү-/дутуу+
----------	---------------------------------	--------------	---------------------------	-------------------------------	--------------

2022	1,560,506.2	500.0	1,163,888.9	125,318.1	271,799.2
2023	2,289,046.3	125,318.1	2,684,980.2	1,196.1	(271,811.9)
2024	3,437,069.8	1,196.5	3,438,364.8	-	(98.5)
Нийт дүн	7,286,622.3	127,014.6	7,287,233.9	126,514.2	(111.2)

Хүснэгтээс харахад 2022 онд 271.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу, 2023 онд 271.8 сая төгрөг илүү олгосон нь 2022 онд таригдсан шүлхий өвчний санхүүжилт он дамжиж ирсэнтэй холбоотой байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд үйлчилгээний хөлс олгохдоо нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг бүрэн мөрдөж ажиллаагүйтэй холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Үйлчилгээний хөлсийг 2022-2024 онд 0.1 сая төгрөгөөр зөрүүтэй тооцож олгосон.
- Листериоз, ДХХ, Цусан халдвар, Энтербактериоз, Колибактериоз, ДХХ, Цусан халдварын вакцинуудын давтан тунг тарьсан анхан шатны нотлох баримт байхгүй байхад нэг удаагийн тарилгын баримтын цувааг үндэслэн 2022-2024 онд 2 удаагийн үйлчилгээний хөлсөнд нийт 1,178.1 сая төгрөгийг олгосон. /Зөрчлийн задаргааг хавсралт №1-д харуулав/
- Мал эмнэлгийн газар нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаа, анхан шатны баримтын бүрдэл, вакцинжуулалтын явцад гүйцэтгэлийн хяналт хэрэгжүүлээгүйгээс 2024 онд гүйцэтгэсэн Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын анхан шатны баримтыг хуурамчаар үйлдсэн, засвар оруулсан, тамганы нэр зөрүүтэй, бүдэг тамга дарсан, тамгаар баталгаажуулаагүй зэрэг зөрчилтэй байхад 135.3 сая төгрөгийн үйлчилгээний хөлсийг тооцож олгосон. /Зөрчлийн задаргааг хавсралт №2-т харуулав/
- Гүйлгээг аж ахуйн нэгж тус бүрээр олгосон санхүүжилтийн дүнгээр шивээгүй, нэг аж ахуйн нэр дээр өглөг үүсгээд бичилтээ бөөн дүнгээр хаасан байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7⁶, Мал эмнэлгийн газрын дарга, сумдын Засаг дарга болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй байгуулсан гуравласан гэрээний 3.3.4⁷ дэх хэсэг, Сангийн Сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын хамтарсан 2021 оны 118, А-201 дугаар хамтарсан тушаалын хавсралтын 1.1.1 дэх хэсэг, Сангийн Сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын хамтарсан 2024 оны 06 сарын 17-ний өдрийн А/118, А/148 дугаар хамтарсан тушаалын хавсралтын 1.1.1 дэх заалтуудыг зөрчиж байгаа тул Мал эмнэлгийн газрын дарга, нягтлан бодогч нарт **сахилгын хариуцлага тооцуулах санал** хүргүүлж шийдвэрлэсэн.

Тандалт мониторингийн зардлын талаар:

Тандалт мониторингийн зардалд зориулж улсын төсвөөс 139.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 38.2 сая төгрөг, нийт 177.8 сая төгрөгийг олгосон байна.

Улсын төсвөөс олгосон тандалт, мониторингийн зардлаас 86.9 сая төгрөгийг томилолтын зардалд, 52.7 сая төгрөгийг шатахууны зардалд зориулалтын дагуу зарцуулсан байна.

Орон нутгийн төсвөөс олгож буй тандалт, мониторингийн зардлаас 4.6 сая төгрөгийг бэлэг, дурсгал, хүнсний материал худалдан авч зориулалт бусаар зарцуулсан, 33.6 сая төгрөгийг үйл

⁶ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно

⁷ Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг чанартай, төлөвлөгөөт малыг бүрэн хамруулж, цуваанд малын тамга, утасны дугаар гарын үсэг зурж баталгаажуулан дархлаажуулалт хийсэн малчны хотноос Мал эмнэлгийн нэгдсэн системд гүйцэтгэлийг оруулах”

ажиллагааны зардлын хамт бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс худалдан авахад зарцуулсан байна. Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас 2025 онд гүйцэтгэсэн “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт” аудитаар Мал эмнэлгийн газрын 2024 онд худалдан авсан бэлэг дурсгал, согтууруулах ундаа, аж ахуйн материал болох нийт 4.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож шийдвэрлэсэн байна.

Аудитаар нийт 13 нэр төрлийн өвчнөөс түүвэрлэн 2024 онд гүйцэтгэсэн бог малын мялзан өвчний баримт материалыг шалгахад тухайн өвчлөлд зарцуулсан 1,244.4 сая төгрөгийн 10.9 хувь нь буюу 135.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнийг 2022-2024 онд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан нийт 13,843.1 сая төгрөгт шилжүүлэн тооцоход 1,509.0 сая төгрөгийн эрсдэлтэй байгааг илэрхийлж байна.

Б.2.3 Вакцины хуваарилалт:

Хөвсгөл аймгийн хэмжээнд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2022-2024 онд нийт 6,378.1 сая төгрөгийн вакциныг хүлээн авч, зарцуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №. Вакцины зарцуулалт

/Мянган төгрөг/

Он	Орон нутаг /Худалдаж авсан/	Улсын төсөв /Үнэ төлбөргүй/	Нийт хүлээн авсан вакцин	Зарцуулалт	
				Тарилгад зарцуулсан Вакцин	Вакцины хорогдол
2022	157,183.1	1,329,176.5	1,486,359.6	1,450,424.5	35,935.1
2023	223,203.0	2,555,989.7	2,779,192.7	2,672,823.3	106,369.4
2024	327,661.6	1,784,871.5	2,112,533.1	2,109,103.2	3,429.9
Нийт	708,047.7	5,670,037.7	6,378,085.4	6,232,351.0	145,734.4

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2024 онд нийт 5.2 сая мал /Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан-1212.mn/ тоолуулсан байна. Үүнээс 11 нэр төрлийн өвчний дархлаажуулалтад давхардсан тоогоор 2.8 сая мал буюу нийт малын 54.4 хувийг хамруулсан байна. Үүнийг хавсралт №3-д харуулав. /Бүх малд толгой дараалан таригддаг шүлхий, бог малын мялзан өвчний дархлаажуулалтад хамрагдсан малын тоог хамруулаагүй болно/

Хавсралтад үзүүлсэн мэдээлэлд үндэслэн вакцины хуваарилалтыг дүгнэвэл:

Үзүүлэлт	Үнэлгээ
Өвчлөлийн тохиолдол ба вакцины хуваарилалт уялдаатай эсэх	Өвчлөлийн тоотой уялдаа сул байна.
Малын тоо болон вакцины хуваарилалт уялдаатай эсэх	Дунд зэрэг
Аймгийн дундаж хамрагдалт (54.4%)	Төсвийн хязгаарлалтаас шалтгаалдаг
Нэгдсэн дүгнэлт	Вакциныг малын тоо болон өвчлөлийн тохиолдлыг харгалзахгүйгээр сумдад жигд хуваарилж байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины хуваарилалтыг малын тоонд үндэслэн жигд хуваарилсан байна.

Б.2.4 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт, зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн мэдээллийг олон нийтэд ил тод, ойлгомжтой хэлбэрээр хүргэх үйл ажиллагаа хангалтгүй байна.

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар нь үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Засгийн газрын Gov.mn, “Шилэн ажиллагаа” буюу shilen.gov.mn цахим хуудаснууд дээр цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна.


Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар нь 2023 оноос өмнө <https://hu-vet.opengov.mn/article/517> цахим хуудсаар мэдээ, мэдээллийг хүргэн ажиллаж байсан боловч төлбөр төлөгдөөгүй гэсэн шалтгааны улмаас тухайн цахим хуудас ашиглагдахгүй болсон байна.

Мөн байгууллагын үйл ажиллагааны нийт төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан байна.

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар нь 2022–2024 онд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 13,849.0 сая төгрөгийн санхүүжилт авч бүрэн зарцуулсан боловч шат шатны хяналт сул байснаас анхан шатны баримтын зөрчилтэй 1,313.6 сая төгрөгийн үйлчилгээний хөлс олгосон байна. Мөн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, үр дүнгийн мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх ажил хангалтгүй байна.

Б.3 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын үйл ажиллагаанд технологийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Б.3.1 Мал эмнэлгийн нэгдсэн систем [/https://mahis.gov.mn/](https://mahis.gov.mn/) нь мал эмнэлгийн бүх ажил үйлчилгээг бүртгэх, мэдээллийн суурь баазыг бүрдүүлэх, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, болон малын шилжилт хөдөлгөөн, вакцинжуулалтын үйл ажиллагааг хянах,



нийтийн эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн систем байна.

Мал эмнэлгийн ерөнхий газар нь 2016 оноос “Мал эмнэлгийн нэгдсэн систем 1.0” хувилбарыг хөгжүүлэн салбарын хэмжээнд ашиглаж эхэлсэн бөгөөд тус системийг 2021 онд шинэчлэн сайжруулж “Мал эмнэлгийн нэгдсэн систем 2.0” хувилбарыг

ашиглаж эхэлсэн байна.

Малын эмчийн бүртгэл, сургалт хөгжил, ажиллах эрх, мал эмнэлгийн үйлчилгээний төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт баталгаажуулалт, эм тариа, хэрэгслийн зарцуулалт, тандалт судалгаа, мал эмнэлгийн гэрчилгээ, махны үйлдвэрүүдийн мэдээлэл зэргийг агуулсан байна.

Тус системийн тусламжтайгаар малчин өрхийн мал сүргийн эрүүл мэнд, зах зээлд нийлүүлж буй түүхий эд, мал амьтны мэдээлэл, малын халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлийг хянах боломжтой байна.

Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын шинжээчдийн баг Монголын мал эмнэлгийн салбарын үйл ажиллагааны гүйцэтгэлийн чадавхын үнэлгээ хийсэн бөгөөд МЭНС-2.0 системийг мал эмнэлгийн ажил үйлчилгээг бүртгэх хянахад чухал ач холбогдолтой систем болсон гэж үнэлсэн байна.

МЭНС-д сумдын мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчид мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан оруулж, дархлаажуулалтын ажлын гүйцэтгэлийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд оруулж, хяналтын улсын байцаагчид хянан баталгаажуулах ажлыг гүйцэтгэж байна.

Мал эмнэлгийн нэгдсэн систем нь мэдээллийг нэгтгэн хянах, тоон дүн шинжилгээ хийхэд дэвшил авчирсан боловч интернэт орчин шаарддаг, бүртгэлийн шат дамжлага ихтэй, хэрэглэгчдийн ажлын ачааллыг нэмэгдүүлсэн байна.

Аудитаар тус системийн хэрэгжилтэд хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудал илэрч байна. Үүнд:

1. МЭНС-д сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн нь малчин өрх, мал бүхий иргэдийн малын тоог бүрэн шинэчилж оруулдаггүй.
2. МЭНС-д бүртгэлтэй малчдын мэдээлэл, малын тоо нь аймгийн статистик мэдээний малын тооноос зөрүүтэй байна.
3. МЭНС-д бүртгэлгүй иргэдийн малын дархлаажуулалтын гүйцэтгэлийг оруулахдаа зарим мал бүхий иргэдийн малын вакцинжуулалтын тоог нэмэгдүүлэх байдлаар бүртгэсэн байна.
4. Мал эмнэлгийн улсын байцаагч нарын системээр хэрэгжүүлж буй хяналт нь бодит байдалтай нийцэхгүйгээс хяналт алдагдсан байна.

Мал эмнэлгийн нэгдсэн систем нь мэдээллийг нэгтгэн хянах, ажлын ил тод байдлыг хангах, тоон дүн шинжилгээ хийхэд дэвшил авчирсан боловч хөдөө орон нутгийн нөхцөлд ашиглахад хүндрэлтэй интернэт орчин шаарддаг, бүртгэлийн шат дамжлага ихтэй, хэрэглэгчдийн ажлын ачааллыг нэмэгдүүлсэн, системд тулгуурласан хяналт нь бодит гүйцэтгэлээр тавих технологийн хяналтын үр нөлөөг бууруулах сөрөг талтай байна.

Б.3.2 Аймгийн мал эмнэлгийн газар нь халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд сумдын Засаг дарга, багийн дарга, мал эмнэлгийн тасаг, гэрээт 74 мал эмнэлгийн аж ахуй нэгжтэй хамтран ажиллаж байна.

Аймгийн Мал эмнэлгийн газар, сумдын мал эмнэлгийн тасаг, гэрээт аж ахуй нэгжүүд болон багийн засаг дараг нарын ажлын уялдаа холбоо хангалтгүйгээс дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангаж ажиллаагүйгээс баримтын бүрдэл хангагдахгүй байх
- Багийн дарга нар малчдын малд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх тов, мэдээллийг хугацаанд нь бүрэн хүргэдэггүйгээс, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн тарилгын явц удаашрах, вакцины тарилга хийсэн бүс нутагт хамрагдаагүй үлдсэн малчдын малыг хамруулахын тулд ахин дахин очдог, зарим малчдын малыг бүрэн хамруулахгүй байх.
- Малчдын тамга тэмдгийг бүрэн бүрдүүлэх тал дээр урьдчилан арга хэмжээ авч ажилддаггүйгээс тарилгын жагсаалтад бүртгэгдсэн малчдын тамга тэмдгийг нөхөж даруулах гэж цаг хугацаа алддаг, тамга, тэмдэг дарагдахгүй дутуу үлддэг.
- Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн малын эмч нь хариуцсан бүс нутгийнхаа малчдын малд малын халдварт өвчнөөс сэргийлэх вакцин хийхдээ тухайн вакцины үүсэл гарал, хаана хэдэн онд үйлдвэрлэгдсэн, хэдэн хоногийн дараа дархлаа тогтдог талаар мэдээлэл өгдөггүй.
- МЭНС-д сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн нь малчин өрх, мал бүхий иргэдийн малын тоог бүрэн шинэчилж оруулдаггүйгээс аймгийн статистик мэдээний малын тооноос зөрүүтэй.
- Сумдын мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч, хяналтын улсын байцаагчид нь вакцинжуулалтын технологийн хяналтыг хангалттай хэрэгжүүлдэггүй, малчдад мал эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаа, дархлаажуулалтын процессын талаар мэдээлэл өгдөггүйгээс малчид ямар төрлийн вакцин таригдсан, малыг хэд хоногийн дараа хүнсэнд хэрэглэх талаар мэдлэг мэдээлэлгүй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7⁸ дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6⁹, 9.7¹⁰ Мал эмнэлгийн газрын даргын баталсан сумдын мал эмнэлгийн тасгийн хяналтын улсын байцаагч, Засаг дарга болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн 2024 онд байгуулсан гурвалсан гэрээний 3 дугаар зүйлийн 3.2.4¹¹, 3.2.5¹² дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Дээрх зөрчлүүдээс харахад малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, албан хаагчдын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.

Б.3.3 Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга, мал эмнэлгийн тасаг, тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй гурвалсан гэрээ байгуулж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх мал эмнэлгийн үйлчилгээг гүйцэтгүүлнэ гэж заасны дагуу Мал эмнэлгийн газар нь 74 мал эмнэлгийн нэгжтэй гэрээ байгуулж ажилласан байна.

Үүнээс Хөвсгөл аймгийн Арбулаг, Баянзүрх, Цэцэрлэг, Цагаан-Уул зэрэг сумдын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд ногдох малын тоо болон вакцин, тарилгын үйлчилгээний хөлсийг харилцан адилгүй хуваарилсан байна. Үүнийг графикаар харуулбал дараах байдалтай байна.

Хамтран ажиллах 2024 оны гэрээний малын тоо.



Графикаас харахад Мандал буян дэлгэрэх ХХК, Агар мөрөн ЭНТ, Таг дүүрэн сүрэг ХХК, Буман цагаан хоршоо зэрэг мал эмнэлгийн аж ахуй нэгжүүдэд 2-3 дахин их мал амьтныг харилцан адилгүй хуваарилсан гэрээ байгуулж тарилгын ажлыг гүйцэтгүүлж санхүүжүүлсэн байна. Энэ нь

⁸ “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”,

⁹ “Дархлаажуулалтыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага болон мал эмнэлгийн тасаг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавина”,

¹⁰ “Дархлаажуулалтын технологийн хяналтыг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, үр дүнгийн хяналтыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори, шаардлагатай тохиолдолд улсын мал эмнэлгийн лаборатори хэрэгжүүлнэ”,

¹¹ “... гүйцэтгэлийн чанарт явцын болон технологийн хяналт, шалгалт хийж танилцуулга, дүгнэлт гарган МЭГ-т ирүүлэх”,

¹² “Сумын малчин өрхүүдээр улиралд 1-с доошгүй удаа явж, мал эмнэлгийн бодлого, үйл ажиллагааг малчдад хүргэх, Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг товлосон товлосон хугацаанд гүйцэтгэсэн эсэхэд МЭҮН-ийн гэрээт малчин өрхийн 30-аас доошгүй хувьд хяналт шалгалт хийж өрхийн эрүүл мэндийн дэвтрийн бичилтийг гүйцэтгэлтэй нь тулган шалгах, малчдын санал хүсэлтийг сонсож, мал эмнэлгийн үйл ажиллагааг сурталчлан таниулах”

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартын 7 дугаар зүйлийн 7.1.3¹³ дэх заалттай нийцэхгүй байна.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг малын тоо, бүс нутгийн онцлогт нийцүүлэн хуваарилсан хэдий ч зарим мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулахдаа мал, амьтны тоо, толгойг харгалзахгүйгээр 2-3 дахин олон мал, амьтныг хуваарилан давуу байдал олгож байгаа нь харагдаж байна.

Дээрх 74 аж ахуйн нэгжийн гэрээний хэрэгжилтийг аудитаар хянахад дараах зөрчилтэй асуудал илэрч байна. Үүнд:

1. Малд үйлчилгээ үзүүлсэн тухай тэмдэглэлээ малын эрүүл мэндийн дэвтэрт тухай бүр бичилт хийж хэвшээгүй
2. Цагаан-Уул сумын "Бүрэнтөгс хайрхан ХХК" мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь итгэмжлэгдсэн малын эмчгүй, мал эмнэлгийн мэргэжлийн үйлчилгээ эрхлэх эрхгүй 2024-2025 онд үйл ажиллагаа явуулж байхад Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар нь 2024-2025 онд ажил гүйцэтгүүлэх хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан байна. Энэ нь Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1¹⁴, 30.4¹⁵, 30.22¹⁶ дахь заалтуудтай нийцэхгүй байна. **Зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн!**
3. Мал эмнэлгийн газар нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаа, анхан шатны баримтын бүрдэл, вакцинжуулалтын явцад шат шатны гүйцэтгэлийн хяналт хэрэгжүүлээгүйгээс 2024 онд гүйцэтгэсэн Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын анхан шатны баримтыг хуурамчаар үйлдсэн, засвар оруулсан, тамганы нэр зөрүүтэй, бүдэг тамга дарсан, тамгаар баталгаажуулаагүй байхад санхүүжилтийг олгосон нийт 135.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7¹⁷ дахь заалт, Мал эмнэлгийн газрын дарга, сумдын Засаг дарга болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй байгуулсан гурвалсан гэрээний 3.3.4¹⁸ дахь хэсэгт заасантай тус тус нийцэхгүй байгаа тул холбогдох 46 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд **төлбөрийн акт** тогтоож шийдвэрлэсэн.
4. Ноён хошуу ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Янжинлхам нь Алаг-Эрдэнэ сумын тархвар зүйчээр ажиллаж байгаад 2025 оны 2 дугаар сард ажлаас чөлөөлөгдсөн, 2025 оны 5 дугаар сард Мал эмнэлгийн газартай гэрээ байгуулан ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2¹⁹ дахь заалттай нийцэхгүй байна. **Зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн!**
5. Цагаан-Уул сумын Буман цагаан хоршоо нь тус сумын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Т.Чандмаагийн нэгдмэл сонирхол бүхий аж ахуйн нэгж байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс

¹³ "Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлэх үед нэг малын эмчийн хариуцах малын тоо хонин толгойд шилжүүлснээр дөчин мянга (40.000)-аас ихгүй байна"

¹⁴ "Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл бүхий малын эмчтэй, стандартын шаардлага хангасан байр, тоног төхөөрөмжтэй, мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд байна"

¹⁵ "Итгэмжлэлтэй малын эмч дангаараа, эсхүл итгэмжлэлтэй малын эмчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан хуулийн этгээд мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулж, харьяалах аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлснээр мэргэжлийн үйлчилгээ эрхлэх эрхтэй болно",

¹⁶ "Мал эмнэлгийн техникийн ажилтан бие даасан үйл ажиллагаа явуулах эрхгүй"

¹⁷

¹⁸

¹⁹ "Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно"

урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3²⁰ дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1²¹ дахь заалтуудтай нийцэхгүй байна. /Сахилгын арга хэмжээ тооцуулах албан шаардлага хүргүүлсэн/

Аймгийн Мал эмнэлгийн газар нь аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг дүгнээгүй, үр дүнг тооцоогүй, сумдын мал эмнэлгийн тасаг нь гэрээт аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн болон технологийн хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, МЭНС цахим системээр хийж байгаа хяналт нь нэр төдий байгаа зэргээс харахад тухайн үйл ажиллагаанд ашиг сонирхлын нэгдмэл байдлыг бий болгож, малын эрүүл мэндийг хамгаалахад улс, орон нутгийн төсвөөс зарцуулж байгаа хөрөнгийн үр ашиг буурч, зарим сумдад хяналтын тогтолцоо алдагдахад хүргэсэн байна.

Б.3.4 Хөвсгөл аймгийн Засаг дарга нь 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ гэсэн зорилтын хүрээнд 3 арга хэмжээг тусган хэрэгжүүлж, үр дүнг нь тооцон ажилласан байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийн гүйцэтгэл үр дүнг Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс дараах байдлаар үнэлсэн байна.

Зорилт арга хэмжээнүүдийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хувь

№	Зорилт	Арга хэмжээ	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	2022 оны үнэлгээ	2023 оны үнэлгээ	2024 оны үнэлгээ
1	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ	Халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа хийх, тэмцэх арга хэмжээнд мал, амьтныг хамруулах	2,875.2 мян.тол мал	2,360.0	2,430.0	90%	90%	100%
2		Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд мал, амьтныг хамруулах	6,027.1 /мал, амьтан/	6,977.2	7,019.0	100%	90%	100%
3		Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын байдалтай уялдуулан халдваргүй өвчний эм бэлдмэлийн нөөц бүрдүүлэх, зүй бусаар хорогдсон малын сэг зэмийн устгал хийх ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулах	850.0м2	820.5	831.3	100%	90%	100%

Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа хийх, тэмцэх арга хэмжээний суурь үзүүлэлтийг 2,875.2 мянган толгой малаар тооцсоноос 2022 онд 2,383.0

²⁰ "Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна",

²¹ "Албан тушаалтан албан үүрэгээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно"

мянга, 2023 онд 2,406.0 мянга, 2024 онд 2,430.0 мянга хүрсэн нь 2022-2024 оны хүрэх түвшний үзүүлэлтээр 93.3 хувиар үнэлэгдсэн..

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд 6,027.1 мянган мал, амьтан хамруулахаар суурь түвшнийг тооцоолсноос 2022 онд 6,991.1 мянга, 2023 онд 7,005.0 мянга, 2024 онд 7,019.0 мянга хүрснээр 2022-2024 оноор нийт 96.6 хувиар үнэлэгдсэн байна.

Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын байдалтай уялдуулан халдваргүй өвчний эм бэлдмэлийн нөөц бүрдүүлэх, зүй бусаар хорогдсон малын сэг зэмийн устгал хийх ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулах арга хэмжээний суурь түвшнийг 850.0м2-аар тооцоолсноос 2022 онд 824.1 мянга, 2023 онд 827.7 мянга, 2024 онд 831.3 мянга хүрсэн нь 2022-2024 оны хүрэх үзүүлэлтээр 96.6 хувиар үнэлэгдсэн байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2022 онд 110.5 мянган тогой мал гоц халдварт болон халдварт өвчнөөр өвчилж байсан бол дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажилласнаар 2024 оны байдлаар халдварт өвчний 65 тохиолдол бүртгэгдсэн бол, гоц халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй үзүүлэлттэй байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс 2022-2024 онуудад 90-100 хувьтай хэрэгжсэн гэж дүгнэсэн байна.

Аудитаар нийт 1,313.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж 135.3 сая төгрөгийн зөрчилд 46 төлбөрийн акт тогтоож, 1,178.1 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 4 албан шаардлага, зөрчил таслан зогсоох 2 албан шаардлага, 0.1 сая төгрөгийн 7 зөвлөмж хүргүүлж шийдвэрлэсэн.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хууль болон түүнтэй уялдуулан гарсан журам заавар, стандартад мал амьтны эрүүл мэндийг хамгаалах нэгдсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх бүтэц, үйл ажиллагаа болон хяналтын тогтолцоог хууль тогтоомжоор тодорхойлсон ба Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газар нь аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан мал амьтныг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилт арга хэмжээнд нийцүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулан батлуулжээ.
2. Хөвсгөл аймагт мал амьтны эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгаа боловсон хүчний нөөцийг аудитаар хянахад насны хувьд 60-аас дээш хувь нь 50-аас дээш насныхан бөгөөд малын эмчээр болон техникийн ажилтнаар ажиллах хүний нөөц дутагдалтай, 1 малын эмчид ноогдох малын тоо стандартаас (100.0 мянга)-аар хэтэрсэн байгаа нь цаашид тухайн салбарт ажиллах боловсон хүчний асуудлыг бодлогын хэмжээнд тавьж шийдвэрлүүлэх цаг болсныг харуулж байна.
3. Мал эмнэлгийн нэгдсэн систем нь мэдээллийг нэгтгэн хянах, ажлын ил тод байдлыг хангах, тоон дүн шинжилгээ хийх, мал эмнэлийн албан хаагчдын ажлын ачааллыг хөнгөвчлөх, цахим хяналт хэрэгжүүлэхэд дэвшил авчирсан боловч хөдөө орон нутгийн нөхцөлд ашиглахад хүндрэлтэй, интернэт орчин шаарддаг, бүртгэлийн шат дамжлага ихтэй, хэрэглэгчдийн ажлын ачааллыг нэмэгдүүлсэн, системд тулгуурласан хяналт нь бодит гүйцэтгэлээр тавих технологийн хяналтын үр нөлөөг бууруулах сөрөг талтай байна.
4. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын технологийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын чанар, үр дүн буурах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд нь гэрээнд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлдэггүй, алслагдсан бүс нутгийн малчдын малыг бүрэн хамруулахгүй байх эрсдэлүүдийг бий болгосон байна.
5. Аймгийн Мал эмнэлгийн газар нь аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг дүгнээгүй, үр дүнг тооцоогүй, сумдын мал эмнэлгийн тасаг нь гэрээт аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт болон гүйцэтгэлийн хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, МЭНС цахим системээр хийж байгаа хяналт нь нэр төдий байгаа зэргээс харахад тухайн үйл ажиллагаанд ашиг сонирхлын нэгдмэл байдлыг бий болгож, малын эрүүл мэндийг хамгаалахад улс, орон нутгийн төсвөөс зарцуулж байгаа хөрөнгийн үр дүн буурч, зарим сумдад хяналтын тогтолцоо алдагдахад хүргэсэн байна.
6. Хөвсгөл аймгийн хэмжээнд 2022-2024 онд малын халдварт өвчний тохиолдол буурсан үзүүлэлттэй байгаа нь аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан “Мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, гоц халдварт өвчингүй тайван бүс нутгаа баталгаажуулна” зорилтын хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Бүх шатны Засаг дарга нарт:

1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг харьяалагдах бүс нутгийн хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.
2. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд ногдох малын тоог тэнцвэртэй хуваарилж, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй байгуулсан гуравласан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох

Мал эмнэлгийн газрын дарга улсын ахлах байцаагч Л.Ариунаад:

3. Сумдын Засаг дарга, мал эмнэлгийн тасгийн хяналтын улсын байцаагч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг бодитой дүгнэж, зарцуулсан хөрөнгийн үр дүнг тооцож ажиллах.
4. Хөрөнгийн зарцуулалтад нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.
5. Тухайн суманд үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн ажлын ачааллыг харгалзан малын тоог жигд хуваарилах ажлыг зохион байгуулах.
6. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд тавих шат шатны хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах.
7. Цагаан-Уул сумын “Буман цагаан хоршоо” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн, хяналт тавьж ажиллах.